Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд тусалцаа авах *шаардлагагүй* гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Дархан сумын Залуучууд театрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Өөрийн байгууллагын онцлог нөхцөлд тулгуурлан хууль эрх зүйн орчин болон, үйл ажиллагааныхаа хүрээнд нэмэлт өөрчлөлтүүдийг тушаал гарган хавсаргасан байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Дархан сумын Залуучууд театрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн цалин хөлсний бодлогод МУ-ын ЗГ-ын тогтоолын дагуу өөрчлөлт орсон байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 591,021.3 мянган төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	324,621.50	24,258.28	(300,363.22)
Авлага	7,740.40	7,740.40	0

Бараа материал	644,796.60	762,657.95	117,861.35
Үндсэн хөрөнгө	5,646,300.40	6,419,823.65	773,523.25
<b>Нийт хөрөнгө</b>	<b>6,623,458.90</b>	<b>7,214,480.28</b>	<b>591,021.38</b>
Өр төлбөр	7,740.40	7,740.40	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,615,718.50	7,206,739.88	591,021.38
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>6,623,458.90</b>	<b>7,214,480.28</b>	<b>591,021.38</b>

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 300,363.22 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны төсвийн үлдэгдэлийг татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 117,861.35 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 20-ний өдрийн №А/17 тоот “хөрөнгө дансны нэр, ангилал шилжүүлэн бүртгэх зөвшөөрөл олгох тухай” тушаалаар 41,763.14 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байсан урлагийн хувцсыг бараа материалын дансанд шилжүүлэн авсан байна. Мөн АЗДТГ-ын тушаал Баяр наадам нээлт ОНХөрөнгө оруулалтаар 19,900.0 мянган төгрөг, УТХО-аар 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн №01-А/491 тоот ДУА-ын Засаг даргын захирамжийн гүйцэтгэл бараа материалын дансны бүртгэлд 1,718.0 мянган төгрөг. 2024 онд шинээр хийгдсэн уран бүтээлийн хувцас хэрэгсэл дотоодын үйлдвэрлэлээр 69,307.1 мянган төгрөг нэмэгджээ. Мөн байгууллагын даргын шийдвэрээр өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэж, тооллогын комисс 2 удаа тооллогоо хийж 3 эд хариуцагчийн цаашид ашиглалтын шаардлага хангахгүй болсон хуучирч муудсан, дахин тоглох боломжгүй уран бүтээлийн тайз жижиг хэрэглэлийг бусад хангамжийн материалын дансны 47,188.43 төгрөгийн бараа материал акталж устгалд оруулсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэлд тайлант онд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

1. 2024 оын 06 дугаар сарын 20-ний өдрийн №А/16 тоот, №А/17 тоот ДУА-ын орон нутгийн өмчийн газрын даргын тушаалаар дансны нэр, ангилал шилжүүлэн бүртгэх зөвшөөрөл олгох тухай, ашиглалтын хугацааг сунгаж ашиглах боломжтой хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэж ашиглалтын хугацааг нэмэгдүүлсэн байна. Үүнд: МТТ-4,368.0 мянган төгрөг, Тавилга эд хогшил-37, 345.1 мянган төгрөг, Бусад үндсэн хөрөнгө- 8,837.12 мянган төгрөг, биет бус хөрөнгөд -53,800.0 мянган төгрөг хөгжмийн зохиол, уран бүтээлийн эзэмших эрх зохиолууд гэх мэт
2. 2024 оны 07 дугаар сарын 03-ний №01-А/313 тоот ДУА-ын Засаг даргын захирамжаар цаашид ашиглах боломжгүй МТТөхөөрөмж данс 12 нэр төрөл 20 ш 17,979.8 мянган төгрөг, Тавилга эд хогшил 11 нэр төрөл 1,326.5 мянган төгрөг, Бусад үндсэн хөрөнгө 4,730.97 мянган төгрөг, Программ хангаж 1 нэр төрөл 1,124.3 мянган төгрөг, Тоглолтын хувцас- 20,030.64 төгрөг тус тус акталж устгалд оруулжээ.
3. УТХО-аар 2024 07 дугаар сарын 03-ний №01-А/314 тоот ДУА-ын Засаг даргын захирамж МТТөхөөрөмж данс 14 нэр төрөл 37 ш 144,156.5 төгрөг компьютер техник хэрэгсэл, мөн УТХО-аар 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр №01-А/491 тоот ДУА-ын Засаг даргын захирамж МТТөхөөрөмж данс 72 мкв лед дэлгэц иж

- бүрэн 229,607.61 мянган төгрөг, Зөөврийн карказан тайз иж бүрэн 152,281.0 мянган төгрөг тус тус хөрөнгүүдийг хүлээн авч бүртгэлд тусгасан
4. ОНТХО-аар 2024 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн №13 тоот ДУА-ын ИТХурлын тогтоолоор нийтийн эзэмшлийн талбайд хийгдсэн доорх ажлуудыг хүлээн авч бүртгэлд тусгасан.Үүнд:
- ❖ Бетон талбай авто зогсоол-185,666.78 мянган төгрөг
  - ❖ Асфальтан талбай гадна талбай-394,854.7 мянган төгрөг тус тус нийт дүнгээр 1,104,848.59 мянган бүртгэлжүүлэн ажилласан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,031,660.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоор 10,000.0 мянган төгрөг, орон нутгийн санхүүжилтээр 159,280.00 мянган төгрөг нийт зарлагыг 4,200,940.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төслийн саналаас 2024 оны 4,200,940.0 мянган төгрөгийн зардлыг 3,476,594.0 мянган төгрөг болгож, 724,346.0 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна. Энэ нь 2024 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулсан хэдий ч бууруулж ирсэн байна.

Зарцуулагдаагүй өмнөх оны харилцахын үлдэгдэл, төсвийн хэмнэлтээс 328,157.78 мянган төгрөг улсын төсөвт, орон нутгийн төсвийн хэмнэлтээс 4,681.17 мянган төгрөг төвлөрүүлсэн байна. Тэтгэвэрт гарахаар саналаа хүргүүлсэн боловч аваагүй 1 хүн ТГОНУТ 21,290.86 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагч 1 хүн ажлаас гарсан 7,638.0 мянган төгрөг үлдээсэн байна.

*Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

д/д	Хөтөлбөр	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71702-Соёл урлаг	80101- Үндсэн үйл ажиллагаа	2,830,013.10	2,829,684.78	(328.32)	99.99
2		80214-Уран бүтээл хийлгэх	40,000.00	40,000.00	0.00	100.00
3		80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	102,341.20	73,412.30	(28,928.90)	71.73
4		81855-Гүйцэтгэл сууриласан санхүүжилт	62,960.20	62,960.17	(0.03)	100.00
5		83603-Дээд шатны төсвөөс	282,000.00	276,798.79	(5,201.21)	98.16
6		80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	159,280.00	131,964.88	(27,315.12)	82.85
Дүн			3,476,594.50	3,414,820.92	(61,773.58)	98,22

❖ Тайлант онд 101 орон тоо батлагдан ирсэн байна. Орон тоогоор бүрэн ажилласан байна.

❖ **Ахмадын сан :**

Тайлант онд ахмадын сангийн журмын дагуу нэг удаагийн тэтгэмж урамшуулал 300.0 мянган төгрөг ахмад уран бүтээл нас барсны хүндэтгэлд үзүүлсэн. Ахмадуудад цагаан сар болон ахмадын баяраар арга хэмжээ зохион байгуулж бараа үйлчилгээний бусад зардлын ангиллаар 11,236.0 мянган төгрөгийн ажил гүйлгээ гаргаж тайлагнасан байна.

Ахмадын сангийн үлдэгдэл 24,258.3 мянган төгрөг 100190035501 тоот дансанд үлдсэнийг төрийн сангийн үлдэгдэл баталгаажуулан харуулжээ.

❖ **Дээд шатны нэмэлт төсөв -83603 хөтөлбөр арга хэмжээний хүрээнд :**

Тайлант онд дээд шатны нэмэлт төсвөөр өөрийн үндсэн үйл ажиллагааны орлого болон АЗДТГ-ын үйл ажиллагааны зардлын санхүүжилтийг хүлээн авч тайлагнасан байна. Үүнд:

#### **АЗДТГ-ын үйл ажиллагааны хүрээнд**

- АЗДТГ-ын тушаал №02-А/128 Ардын хувьсгалын -ын 103 жил Үндэсний баярын наадмын санхүүжилт -80948.25 мянган төгрөг
- АЗДТГ-ын тушаал №02-А/177 тушаалын санхүүжилт Дархан хотын баярын зардал ОХУ болон Сэлэнгэ Төв аймаг хамтарсан тоглолт 6000.0 мянган төгрөг.
- АЗДТГ-ын тушаал №02-А/226 Шилдэг уран бүтээлийн зардал уран бүтээлийн зардлын санхүүжилт- 5 000.0 мянган төгрөг
- Соёлын бүтээлч сарын аяны хүрээнд Соёл урлагийн газраас 1 000.0 мянган төгрөг нийт 92,948. 3 мянган төгрөг орон нутгаас холбогдох үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн ажиллуудыг дээд шатны нэмэлт санхүүжилт авч бараа үйлчилгээний болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлуудаар тус тус тайлагнаж ажиллажээ.

#### **Өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоор**

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд төсөвт тусгасан боловч дутуу ирсэн учраас дараах зардлын ангилалуудад хувиарлалт хийлгэж ажилласан байна. Үүнд:

- Үндсэн цалин 36,000.0. мянган өгрөг
- Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл 10,000.0 мянган төгрөг
- Шуудан холбоо интернэтийн төлбөр-855,4 мянган төгрөг
- Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн ариутгал устгал-651.0 мянган төгрөг
- Нормын хувцас зөөлөн эдлэл-630.0 мянган төгрөг
- Багаж техник хэрэгсэл-19,926,7 мянган төгрөг
- Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох-314 мянган төгрөг
- Мэдээлэл технологи үйлчилгээ 460. 1 мянган төгрөг
- Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал-34,999.8 мянган төгрөг
- Бараа үйлчилгээний бусад зардал-27,048.87 мянган төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг үйлчилгээний төлбөр хураамж 53,774.1 мянган төгрөг тус тус нэмэгдүүлэн авч тайлагнасан байна.

#### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд 71702/80214 хөтөлбөрийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Тайлант онд Залуучууд театр нь 2024 Өнөд өвлөгдөх өв концерт, Найрамдлын Дархан, Дээрэмчид драм жүжиг, Муурын байшин хүүхдийн жүжиг, Шидэт миний хөөрхөн шүдний аялал хүүхэлдэйн жүжиг 5 шинэ уран бүтээл туурвиж ажиллажээ. Шинээр хийсэн уран бүтээлээс нийтэд нь 51,538.0 мянган төгрөгийн орлого олжээ.

Хүснэгт 2. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц орлого	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Муурын байшин	2024	2024.05 сар	34,808.00	23,286.10	23,286.10
2	Өнөд өвлөгдөх өв концерт	2024	2024 07 сар	Баяр наадам	32,668.20	32,668.20
3	Найрамдлын Дархан	2024	2024 10 сар	Хотын баяр	8171,0	8171,0
4	Шидэт миний хөөрхөн шүдний аялал хүүхэлдэйн жүжиг	2024	2024.11 сар	16,730.00	2,504.00	2,504.00
5	Дээрэмчид драм жүжиг	2024	2024.12 сар	2025 онд тоглоно	13,357.48	13,357.48
ДҮН				51,538.00	80 086,78	80 086,78

Байгууллагын 2024 онд орон нутгаас хийгдэж буй нэмэлт төсвийн хүрээнд дээд шатны байгууллагад хүргүүлж орлогын хувиарлалт хийлгэж 71702/83603 хөтөлбөр зориулалтаар зарцуулалт хийсэн байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

2024 оны худалдан авах ажиллагааг урсгал төсвийн хүрээнд хуулийн дагуу хугацаанд нь tender.gov.mn, shilendans.gov.mn сайтуудаар байршуулан нийтэлж, тайланг цахим болон цаасаар хүргүүлж ажилласан байна.

Улс, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар тендер зарлагдсан 1,104, 848.6 мянган төгрөгийн техник тоног төхөөрөмжийг хүлээн авч бүртгэлд тусгахын хамт шилэн дансанд байршуулан ажиллажээ. tender.gov.mn сайтаар шууд худалдан авалтын тайланг цахим сайтаар бүрэн нийтэлж, тайлагнаж ажилласан байна.

## АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн дугаар Залуучууд театрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах санхүүгийн тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмж тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит” ХХК-ийн аудитор Б.Хоролбат гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Магсаржалам, гүйцэтгэх захирал С.Оргил нар дараагийн шатны чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн дугаар Залуучууд театр нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит” ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлан дахь нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардал 2,677,490.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 53,549.8 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Дархан-Уул аймгийн Залуучууд театр нь нэг хөтөлбөр 6 арга хэмжээний хүрээнд нийт дүнгээр 61,773.58 мянган төгрөг хэмнэлт гаргаж ажилласан байна. Үүнд:

- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 27,314,46 мянган төгрөг,
- Нормын хувцас, зөөлөн эдлэл 4,556.0 мянган төгрөг,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 228,1 мянган төгрөг,
- Хангамж бараа материалын зардал 546.16 мянган төгрөг,
- Урсгал зардал 980 төгрөг төгрөг,
- Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 200 төгрөг,
- ТГОНУТэтгэмж нэг хүн аваагүй 21,290,86 мянган төгрөг,
- Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох мөнгөн тэтгэмж 7,638,0 мянган төгрөг нэг хүн ажлаас гарсан зэрэг тус тус хэмнэж зарцуулсан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 4 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамааруулан шалгалаа.

Дархан-Уул аймгийн дугаар Залуучууд театр нь 2024 онд мэдээлбэл зохих 169 мэдээллийн хуульд заасан хугацаанд бүрэн байршуулсан байгаа тул шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд гарсан алдаа, зөрчилтэй асуудал байхгүй.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дархан-Уул аймгийн дугаар Залуучууд театрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 7,564.7 мянган төгрөгийн зөрчил илэрсэн тул цаашид үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах 2 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилтийг шалгахад 100 хувь хэрэгжсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	7,564.7	2	7,564.7	100.0
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>7,564.7</b>	<b>2</b>	<b>7,564.7</b>	<b>100.0</b>

#### АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 36,585.9 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Цалин хөлс нэмэгдэл, урамшуулал зардал 943.1 мянган төгрөгийг хооронд нь гүйлгэн бүртгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам", санхүүгийн тайлангийн "Ангилал" Нийцсэн бөгөөд

зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул үр дүнгийн тайлангийн цалингийн зардалд хаагдаагүй тул залрууллаа.

2. Бараа материалын данснаас үндсэн хөрөнгөнд 35,642.8 мянган төгрөгийн биет бус хөрөнгөнд бүртгэхдээ зардлын данснаас хасалт хийж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар"-ын 3.4 дэх хэсэг, санхүүгийн тайлангийн аудитын “Ангилал”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн үр дүнгийн тайлангаас хасалт хийн бүртгэж залруулсан.

Аудитаар нийт 23,217.6 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 1,293.8 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 21,923.8 мянган төгрөгийн цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах 3 зөвлөмж өгсөн

## **5.1 Төлбөрийн акт**

Аудитаар дараах зөрчилд төлбрийн акт тогтоолоо.

Монгол Улсын Соёлын яамны албан тоот байгууллагын даргын 2024 оын Б/41, 2024 Б/98 тоот тушаалын дагуу нягтлан бодогчид балансын урамшуулал давхардуулан олгосон нь байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтаныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1,5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй нь нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## **5.2 Албан шаардлага**

Аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

## **5.3 Зөвлөмж**

### **5.3.1. Бараа материал данстай холбоотой асуудал**

#### **5.3.1.1 Илрүүлэлт:**

Автомашин шатахуун зарцуулалтын норм тогтоогоогүй, жолоочийн тооцоог бодоогүй, зардлыг тооцооллын дагуу бодитоор зардалд тусгаж баталгаажуулаагүй 6,983.0 мянган төгрөг тайлагнасан байна.

#### **5.3.1.2 Өгсөн зөвлөмж:**

Шатахууны тооцоог сар бүр бодож, зардалд бодитоор тусгаж, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх

### **5.3.2. Авлагын холбоотой асуудал**

**5.3.2.1 Илрүүлэлт:** Авлагын дансны үлдэгдэл 7,470.4 мянган төгрөг авлагын үлдэгдэл тодорхой бус авах эсэх нь эргэлзээтэй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

---

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 5.3.2.2 Өгсөн зөвлөмж:

Төсвийг зөв зохистой удирдаж, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, авлага үүсгэхгүй ажиллах.

### 5.3.3. Өр төлбөрийнданстай холбоотой асуудал

5.3.1.1 Илрүүлэлт: Ар төлбөрийн дансны үлдэгдэл 7,470.4 мянган төгрөг авлагын үлдэгдэл тодорхой бус авах эсэх нь эргэлзээтэй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

### 5.3.2.2 Өгсөн зөвлөмж:

Төсвийг зөв зохистой удирдаж, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, авлага үүсгэхгүй ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>3</sup>-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
БМ дансаас үндсэн хөрөнгөрүү буруу бичилт хийсэн	1	35,642.8			1	35,642.8	1	35,642.8				
Цалингийн зардал бичилт буруу хийсэн	1	943.1			1	943.1	1	943.1				
Дүн	2	36,585.9			2	36,585.9	2	36,585.9				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

<sup>3</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Авлага үүсгэсэн	1	7,470.4					1	7,470.4				
Өглөг үүсгэсэн	1	7,470.4					1	7,470.4				
Түлш шатахууны тооцоо бодоогүй	1	6,983.0					1	6,983.0				
	1	1,293.8	1	1,293.8								
Дүн	4	23,217.6	1	1,293.8			3	21,923.8				



Хүснэгт Б. Санхүүгийн тайлангийн түвшинд болон ач холбогцтой бий АГАДҮТ-ыг үнэлсэн алба, зөрчлийг шийдвэрлэх

№	Тодорхойлсон эрсдэл	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Материаллаг эсэх	Үр өгөөж тооцох эсэх	Шалгуур үзүүлэлт		Алдаа зөрчлийн ангилал	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу	Гаргасан шийдэл
						Стандартын заалт	Хууль тогтоомжийн заалт					
1	Санхүүгийн тайланг УСНББОУС болон Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан швэрдлагууд болон Сангийн яамнаас гаргасан заавар журмын дагуу иж бүрэн бэлтгээгүй байх	Бараа материалын данснаас Үндсэн хөрөнгийн дансанд 35,642,800 төгрөгийн хөгжмийн зохиол, уран бүтээлүүдийн зохиолуудыг шилжүүлэхдээ зардлын данснаас хасалт хийж хийж тайлагнасан тул залруулав.	35,642,800.00	Материаллаг	Тийм	УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга	НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Сангийн сайдын 2025 оны А/З дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-тай нийцэхгүй байна.	Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой	Санхүүгийн тайланд залруулах			
2		Цалингийн санг шалгахад цалингийн зардал 943,124.00 төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	943,124.00	Материаллаг	Тийм	УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга	НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Сангийн сайдын 2025 оны А/З дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар"-ын 3.4 дэх хэсэг	Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой	Санхүүгийн тайланд залруулах			
Дүн			36,585,924.0									

Бэлтгэсэн:  
Аудитор

Хянасан:

Чанарын хяналтын менежер

Шинжлэн магадлахуй ЗЗШ аудит ХХК-ийн захирал



Б.Хоролбаг  
олноо:

П.Магсаржалан  
Огноо:

С.Оргил  
Огноо:

Танилцаж, зөвшөөрсөн

Дархан-Уул аймгийн Запүүчүүд театр

Дарга М.Ерболот

Нягтлан бодогч М.Отгонбаяр



Огноо:

Огноо:



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 01/48-25720082-2AA-2025/14А-ОТН-ТУ13 Дархан сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дархан-Уул аймгийн Залуучууд театрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд тус байгууллагын нягтлан бодогч М.Отгонбаярт үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 1,293,750.00 төгрөгийн балансын шагнал хэтрүүлэн олгож, төсвийн арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 3.3-т "Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах ниглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3-д "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хууль тогтоомж зөрчиж олгосон нийт 1,293,750.00 (нэг сая хоёр зуун ерэн гурван мянга долоон зуун тавин) төгрөгийг нягтлан бодогч М.Отгонбаяраар төлүүлж, Төрийн сан банкин дахь Да.Хүү, торгуулийн орлогын 100190000988 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дархан-Уул аймгийн Залуучууд театрын дарга М.Ерболот, нягтлан бодогч М.Отгонбаяр нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ ЭЗШ  
АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР:

С.ОРГИЛ

Л.МАГСАРЖАЛАМ

БАТАЛГААЖУУЛСАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Ш.МӨНХБАЯР

4525050091

